



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

2019

ХӨДӨӨ АЖ АХУЙ



Алтай хот
2019 он

Агуулга

ОРШИЛ

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

НЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

I.1 Мал аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

I.2 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлт

I.3 Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

ХОЁР. 2018 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ҮР ДҮН

II. 1 Малтай өрх болон малчин өрх, малдчын тоо, ахуйн зарим үзүүлэлт

II.1.1 Малтай өрх, малчин өрхийн тоо

II.1.2 Малчдын тоо, насны бүлэг

II.1.3 Малчдын ахуйн зарим үзүүлэлт

II. 2. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн

II.2.1 Малын тоо

II.2.2 Нийт сүргийн бүтэц

II.2.3 Иргэдийн хувийн малын тоо

II.2.4 Хээлтэгч мал

II.2.5 Төл бойжилт

II.2.6 Том малын зүй бусын хорогдол

II.2.7 Малын хээл хаялт, сувайралт

II.2.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

II.2.9 Малын хэрэглээний зарлага

II.2.10 Тэжээвэр амьтад

II.2.11 Малжуулалтын талаарх мэдээлэл

II.2.12 Худаг, усан сангийн тоо, усжуулалтын талаархи мэдээлэл

ГУРАВ. МАЛ СҮРГИЙН БЭЛЧЭЭРИЙН ДААЦ, ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ

III. 1 Малын бэлчээрийн даац

III. 2 Тэжээлийн хүрэлцээ, хангамж

ДҮГНЭЛТ

ХАВСРАЛТУУД

Хянасан:

Статистикийн хэлтсийн дарга Д. Тунгалаг

Судалгааг боловсруулсан:

Хөдөө аж ахуй хариуцсан

мэргэжилтэн

Б. Тогтохбаяр

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Хураасан ургац, ургамлын төрлөөр, сумаар
- Хүснэгт 2. Газар тариалангийн үйлдвэрлэл
- Хүснэгт 3. Малтай өрх, малчин өрхийн тоо, сумаар
- Хүснэгт 4. Малтай өрх, малчин өрх, малчдын тоо
- Хүснэгт 5. Малчдын ахуй соёлын үзүүлэлт
- Хүснэгт 6. Малын тоо /мян, тол/
- Хүснэгт 7. Малын тоо, сумаар, төрлөөр, мянган толгойгоор, 2019 он
- Хүснэгт 8. Малын тоо, сумаар
- Хүснэгт 9. Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь, төрлөөр
- Хүснэгт 10. Сүргийн насны ангилалын бүтэц, хувиар
- Хүснэгт 11. Сумдын мал сүргийн бүтэц, хонин толгойд шилжүүлсэн мянган толгойгоор
- Хүснэгт 12. Малтай өрхийн ам бүлийн тоо, тэдгээрийн малын тоо, 2000-2019 он, мянган толгойгоор
- Хүснэгт 13. Иргэдийн хувийн малын бүлэглэлт, 2015-2019 он
- Хүснэгт 14. Хээлтэгч малын тоо
- Хүснэгт 15. Төл бойжилт
- Хүснэгт 16. Том малын зүй бусын хорогдол
- Хүснэгт 17. Хээл хаясан болон сувайрсан эх малын тоо
- Хүснэгт 18. Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь
- Хүснэгт 19. Хээлтүүлэгч малын тоо
- Хүснэгт 20. Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо
- Хүснэгт 21. Малын нийт хэрэглээний зарлага, мянган толгойгоор
- Хүснэгт 22. Оны эхний малд эзлэх хувь
- Хүснэгт 23. Хэрэглээний малын тоо, мянган толгойгоор
- Хүснэгт 24. Тэжээвэр амьтдын тоо
- Хүснэгт 25. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо, ам бүлийн тоо, малжуулалтаас авсан малын тоо, малжуулалтаар зарцуулсан хөрөнгө
- Хүснэгт 26. Шинээр гаргасан худгийн тайлан
- Хүснэгт 27. Засварласан худгийн тайлан
- Хүснэгт 28. Бэлчээрийн хүрэлцээ хангамж
- Хүснэгт 29. Бэлтгэсэн тэжээл, тн

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь
- Зураг 2. Малчин өрхийн тоо, нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь, 2019 он
- Зураг 3. Малчдын насны бүтэц
- Зураг 4. Малчдын нийгэм, ахуйн нөхцлийг харуулах зарим үзүүлэлт
- Зураг 3. 200 хүртлэх малтай өрхийн тоо.
- Зураг 4. 1000-аас дээш малтай өрхийн тоо.
- Зураг 5. Малын тоо, мян.тол /1940-2019 он/
- Зураг 6. Малын тоо, мянган толгойгоор
- Зураг 7. Аймгийн нийт малд сумдын малын эзлэх хувь
- Зураг 8. Малын тоо, сумаар, 2019 он
- Зураг 9. Мал сүргийн бүтэц, хувиар, таван төрлөөр
- Зураг 10. 200 хүртэлх малтай өрхийн тоо, сумаар
- Зураг 11. 1000-аас дээш малтай өрхийн тоо, сумаар
- Зураг 12. Бойжуулсан төл, мянган толгойгоор
- Зураг 13. Том малын зүй бусын хорогдол, тоогоор
- Зураг 14. Малын хээл хаялт, сувайралт, мянган толгойгоор

ОРШИЛ

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль цаг агаараас хамааралтай байх бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгдэж байдаг.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуй, газар тариалангийн салбарын 2019 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

Манай улсын үндсэн хуулинд мал сүргийг үндэсний баялаг мөн гэж томъёолж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

"Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2019 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулав.

Монгол Улсын Засгийн газраас малчдын тэтгэвэрт гарах насыг 5 жилээр багасгах талаар төрийн бодлого хэрэгжиж байгаатай холбоотойгоор хөдөө аж ахуй, нийгмийн салбарын төлөвлөлтөд нарийвчилсан тоо мэдээллийн хэрэгцээ бий болсон юм. Иймд ҮСХ-ны даргын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/185 тоот тушаалаар баталсан тооллогын маягтад малчдын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл, эрчимжсэн мал ахуйтай холбоотой мэдээллийг шинээр нэмж тусгажээ. Өөрөөр хэлбэл мал аж ахуй эрхэлж буй малчин хүн бүрийн мэдээлэл статистикийн мэдээллийн санд орох болсноороо өмнөх жилүүдийн тооллогоос онцлог байлаа.

Энэхүү танилцуулгад мал тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, бэлчээрийн даацын талаар тусгасан.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх.

Малтай өрх. Малчин өрхөөс гадна малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх.

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуйг эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр -1 бод, 6 хонь -1 бод,

1 тэмээ - 1.5 бод, 8 ямаа- 1 бод,

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ- 5 хонь, 1 хонь - 1 хонь,

1 адуу - 7 хонь, 1 ямаа - 0.9 хонь

1 үхэр- 6 хонь,

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр сүүлчийн 2 насны малыг хамруулна.

Тэмээ - 4 настай, 5 ба түүнээс дээш настай

Адуу - 3 настай, 4 ба түүнээс дээш настай

Үхэр - 2 настай, 3 ба түүнээс дээш настай

Бог мал - тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал - Тэмээ - өнгөрсөн жилийн төл, 2, 3 настай Адуу- Өнгөрсөн жилийн төл, 2 настай, Үхэр- Өнгөрсөн жилийн төл Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр сүүлийн 2 насны эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч гаргана. Харьцуулсан үзүүлэлтийг оны эцсийн малын тоог эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно. Малын өсөлтийн орлого тал нь төл бойжилт, зарлага тал нь хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол болно.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 - гаар үржүүлнэ.

Бойжилтийн хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулан гаргана. 1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур 20-25 Бух 35-45

Азарга 12-15 Хуц, Ухна 25-30

Малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг оруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

Малын хэрэглээний зарлага. Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бусын хорогдол, оны эцсийн малын тоог хасч гаргана.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент.

Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж

тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс - 0.45

Таримал тэжээл - 0.35, Даршны ургамал - 0.25

Гар тэжээл, хужир шүү - 1.0, Төмс ногооны хаягдал - 0.22

Үр тарианы хаягдал - 0.9, Лай - 0.4

Сүрэл - 0.25 гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

• Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.

1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.

2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.

3. Шүүст тэжээл- Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.

• Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.

• Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай гэж хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжөөсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай гэж тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээ юм.

Хураасан талбай гэж тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээ юм.

Га-гийн ургац гэж талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо нэг төрлийн ургамлын тариалсан талбайгаас хураан авсан бүх ургацыг тэр талбайн нийт хэмжээнд харьцуулж тодорхойлно. / 1тн=10цн=1000кг /

Нийт ургац нь тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.

Эдийн засгийн бүсэд:

Баруун бүс - Баян-Өлгий, Говь-Алтай, Ховд, Увс, Завхан

Хангайн бүс - Баянхонгор, Булган, Архангай, Өвөрхангай, Орхон, Хөвсгөл аймаг

Төвийн бүс - Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Дархан-Уул аймаг

Зүүн бүс - Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймаг


Улаанбаатар бүс - Улаанбаатар хот

НЭГ. ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛТ

I.1 Мал аж ахуйн салбарын эдийн засагт эзлэх байр суурь

2019 онд аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн 338235.9 сая төгрөгт хүрч үүнээс хөдөө аж ахуйн салбар 150413.8 сая төгрөгт хүрч 44.5 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 1. ДНБ-Д ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН
НЭМЭГДЭЛ ӨРТГИЙН ЭЗЛЭХ ХУВЬ



Мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн тоо 2019 онд 1123.4 мянга болж өмнөх оныхоос 22.2 хувиар өссөн байна.

I.2 Газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт

ХҮСНЭГТ 1. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр, сумаар

Сум	Үр тариа, тн/Cereals, t					Төмс, тн/Potatoes, t				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Бүгд	514.1	525.3	324.1	294.1	559.0	652.6	633.1	831.4	1218.9	576.7
Есөнбулаг	56.0	20.7	43.6	26.6	19.8	136.3	162.0	118.7	146.4	114.9
Алтай	0.0	0.0	0.0	0.0	0.0	2.1	8.0	12.9	13.5	33.0
Баян-Уул	0.0	0.0	0.0	0.0	0.0	5.1	8.3	2.3	7.2	4.5
Бигэр	6.9	2.6	1.5	1.2	2.1	5.4	8.8	7.5	1.6	5.8
Бугат	5.5	1.0	6.0	3.0	0.0	130.0	35.0	30.0	15.5	35.0
Дарив	0.7	0.1	3.5	2.5	1.3	2.4	0.8	2.5	0.9	0.8
Дэлгэр	0.0	0.0	0.0	1.0	0.0	15.6	24.4	6.2	17.5	5.7
Жаргалан	2.0	3.0	0.0	0.0	0.0	9.3	25.2	8.0	2.5	5.5
Тайшир	13.7	30.4	34.5	54.5	141.7	2.0	16.0	56.6	5.0	6.0
Тонхил	0.0	0.0	0.0	0.0	3.0	10.5	17.5	9.0	12.0	2.0
Төгрөг	4.2	7.0	13.5	12.0	12.0	46.9	24.0	18.1	27.0	27.0
Халиун	11.5	10.5	6.0	13.8	159.2	50.4	60.0	326.0	602.2	183.0
Хөхморьт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.7	1.5	0.6	5.0	3.0
Цогт	180.0	190.0	20.0	76.6	13.8	30.0	51.0	60.0	187.0	14.6
Цээл	0.0	0.0	0.0	0.0	0.0	1.4	19.3	22.7	17.3	15.0
Чандмань	231.6	122.0	145.5	66.0	203.0	122.0	52.3	52.3	16.8	24.0
Шарга	2.0	138.0	50.0	36.9	3.1	78.0	95.0	95.0	136.5	95.0
Эрдэнэ	0.0	0.0	0.0	0.0	0.0	4.5	24.0	3.0	5.0	2.0

ХҮСНЭГТ 1. ХУРААСАН УРГАЦ, ургамлын төрлөөр, сумаар /үргэжлэл/

Сум	Хүнсний ногоо, тн/Vegetables, t					Тэжээлийн ургамал, тн/Fodder crops, t				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Бүгд	386.4	468.8	371.1	695.3	435.8	1159.3	1479.0	1577.3	1693.4	1839.3
Есөнбулаг	102.9	101.4	74.9	87.3	71.5	45.0	48.1	67.8	69.7	49.5
Алтай	0.8	3.9	4.8	4.5	22.8	0.0	6.5	1.5	0.0	0.0
Баян-Уул	0.9	0.0	0.7	1.8	1.1	30.0	20.0	0.0	11.0	12.0
Бигэр	7.4	4.1	1.7	3.7	1.5	390.0	486.5	126.6	395.0	368.4
Бугат	38.5	12.3	30.4	20.5	46.0	330.0	229.5	60.0	14.0	320.0
Дарив	0.2	0.8	0.9	0.8	3.3	0.8	0.1	1.0	1.0	4.8
Дэлгэр	15.1	83.7	14.3	46.5	13.7	11.5	22.0	5.0	19.7	22.5
Жаргалан	4.4	4.0	8.8	1.6	2.8	30.0	40.0	17.5	0.0	20.0
Тайшир	1.2	7.4	0.8	2.3	2.0	0.0	115.0	90.0	145.0	180.0
Тонхил	5.0	5.5	3.6	8.0	2.6	0.0	0.5	0.0	0.0	42.0
Төгрөг	34.3	26.5	15.0	20.0	12.1	8.0	2.0	12.0	11.5	0.0
Халиун	65.0	54.9	75.3	68.3	60.3	6.0	105.0	32.1	0.8	3.1
Хөхморьт	0.9	1.7	2.8	11.0	1.5	2.0	0.0	0.0	0.0	5.0
Цогт	30.0	75.3	40.8	280.8	72.5	23.0	10.0	150.0	450.0	395.0
Цээл	0.1	18.1	16.9	28.4	12.1	19.0	2.3	62.8	60.0	9.0
Чандмань	51.5	28.3	8.3	1.2	1.0	264.0	376.5	931.0	493.5	399.0
Шарга	28.2	35.0	70.0	107.5	108.4	0.0	15.0	20.0	22.2	9.0
Эрдэнэ	0.0	6.0	1.0	1.1	0.7	0.0	0.0	0.0	0.0	0.0

ХҮСНЭГТ 2. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Өвс, хадлан, тн	5912.8	5169.3	7568.2	7481.3	8739.5	116.8
Гар тэжээл, тн	190.9	283.2	533.3	750.3	846.8	112.9
Хужир, шүү, тн	1848.8	2879.5	3727.4	4535.5	3912.6	86.3

2019 онд 8739.5 тн өвс хадлан, 846.8 тн гар тэжээл, 3912.6 тн хужир шүү бусад тэжээл бэлтгэсэн байна. 2015 онтой харьцуулахад бэлтгэсэн өвс 47.8 хувиар, гар тэжээл 4 дахин, хужир шүү 2 дахин өссөн байна.


ХОЁР. МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

II.1 Малтай өрх болон малчин өрх, малдчын тоо, тэдний ахуйн зарим үзүүлэлт

II.1.1 Малтай өрх, малчин өрхийн тоо

Аймгийн хэмжээний нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувийг авч үзвэл, 2010 онд 45.8 хувийг, 2015 онд 41.4 хувийг эзэлж байсан бол 2019 онд 45.3 хувийг эзэлж байна. 2010-2014 онд аймгийн нийт өрхөд малчин өрхийн эзлэх хувь жил бүр буурч, 40.8 хувьд хүрсэн бол 2015-2019 онуудад харьцангуй нэмэгдэж, дунджаар 41.445.3 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 2. МАЛЧИН ӨРХИЙН ТОО, НИЙТ ӨРХӨД МАЛЧИН ӨРХИЙН ЭЗЛЭХ ХУВЬ, 2010-2019 ОН



ХҮСНЭГТ 3. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХИЙН ТОО, сумаар мянган өрх

Сум	Малтай өрхийн тоо				2019/ 2018	Малчин өрхийн тоо				2019/ 2018
	2016	2017	2018	2019		2016	2017	2018	2019	
Есөнбулаг	0.49	0.45	0.45	0.43	95.6	0.800	0.839	0.833	0.855	102.6
Алтай	0.23	0.23	0.23	0.23	100.0	0.310	0.308	0.316	0.325	102.8
Баян-Уул	0.5	0.51	0.49	0.49	100.0	0.700	0.701	0.701	0.716	102.1
Бигэр	0.43	0.43	0.41	0.42	102.4	0.560	0.566	0.570	0.583	102.3
Бугат	0.26	0.3	0.29	0.31	106.9	0.480	0.488	0.499	0.517	103.6
Дарив	0.27	0.27	0.24	0.22	91.7	0.450	0.453	0.442	0.433	98.0
Дэлгэр	0.51	0.49	0.49	0.51	104.1	0.720	0.751	0.776	0.797	102.7
Жаргалан	0.35	0.36	0.35	0.39	111.4	0.450	0.461	0.467	0.471	100.9
Тайшир	0.26	0.31	0.33	0.33	100.0	0.370	0.383	0.401	0.416	103.7
Тонхил	0.33	0.37	0.38	0.38	100.0	0.560	0.573	0.571	0.583	102.1
Төгрөг	0.34	0.33	0.33	0.32	97.0	0.490	0.504	0.495	0.507	102.4
Халиун	0.5	0.53	0.53	0.57	107.5	0.630	0.648	0.666	0.677	101.7
Хөхморьт	0.42	0.41	0.41	0.48	117.1	0.620	0.619	0.619	0.632	102.1
Цогт	0.63	0.65	0.65	0.65	100.0	0.840	0.855	0.888	0.898	101.1
Цээл	0.32	0.33	0.35	0.35	100.0	0.470	0.488	0.501	0.518	103.4
Чандмань	0.36	0.43	0.43	0.4	93.0	0.520	0.534	0.541	0.550	101.7
Шарга	0.36	0.4	0.41	0.42	102.4	0.480	0.486	0.491	0.489	99.6
Эрдэнэ	0.35	0.39	0.36	0.36	100.0	0.500	0.523	0.538	0.554	103.0
Бүгд	6.91	7.19	7.13	7.26	-	2,026.0	2,027.2	2,028.3	2,029.5	-


II.1.2 Малчдын тоо, насны бүлэг

2019 оны жилийн эцэст тус аймагт малтай 10521 өрх тоологдсны 7255 өрх буюу 68.9 хувь нь малчин өрх, 3266 өрх буюу 31.1 хувь нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх байна. Өмнөх онтой харьцуулахад малтай өрх 135-р буюу 1.3 хувиар өссөн бол малчин өрх 77-р буюу 1.1 хувиар буурчээ. Малчин өрхийн ам бүлийн тоо нь 26.8 мянга болж нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 4 байна.

ХҮСНЭГТ 4. МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Малтай өрх	9505	9246	9264	9395	9428	9602	9932	10180	10315	10521
Малчин өрх	7185	6994	6644	6537	6436	6658	6903	7183	7106	7255
Нийт малчдын тоо	14776	13889	13311	13118	12949	13294	13691	12919	12391	12287
Үүнээс насны бүлгээр	15-34	6372	5684	5191	4896	4586	4634	4634	4283	3661
	35-54 насны эм, 35-59 насны эр	6659	6587	6792	6917	7189	7741	7741	7423	6994
	Тэтгэвэрийн насны	1745	1618	1328	1305	1174	1316	1316	1213	1440
Нийт малчдаас эмэгтэй	6725	6391	6459	6301	6216	6451	6451	5757	5404	5241
Малчин нэг өрхөд ноогдох малын тоо	157	196	288	340	401	439	506	466	430	496

МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ 2019



Мал аж ахуйн салбарт ажиллаж буй малчдын тоо 2010 оноос жилд дунджаар 6.1-16.8 хувиар буурсан байна. 2019 онд малчдын тоо 12287 болсон нь өмнөх оноос 0.8 хувиар буюу 104 хүнээр буурсан байна. Нийт малчдын 5241 буюу 47.2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Насны бүлгээр авч үзвэл 29.7 хувийг 15-34 насны, 58.9 хувийг нь 35-59 насны, 11.4 хувь тэтгэвэрийн насны хүмүүс эзлэж байна.

Малчин нэг малчин өрхөд 496, малтай нэг малтай өрхөд 342 толгой мал ногдож байгаа нь улсын дунджаас малчин өрхийнх 39, малтай өрхийнх 52 толгой малаар олон байна.


II.1.3 Малчдын ахуйн зарим үзүүлэлт

2019 оны мал тооллогоор аймгийн нийт малчин өрхийн 87.0 хувь нь цахилгаан эх үүсвэртэй, 78.5 хувь нь телевизортой, 64.4 хувь нь автомашинтай, 70.9 хувь нь мотоциклтэй, 98.9 хувь гар утас хэрэглэдэг гэсэн үр дүн гарчээ. Нийт өрхийн дүнд эзлэх хувийг өмнөх онтой харьцуулахад цахилгаан эх үүсвэртэй өрхийн тоо 0.2 пункт, телевизортой өрхийн тоо 0.6 пунктээр өссөн бол малчин өрхийн мотоциклын тоо 198, автомашины тоо 560 ширхгээр тус тус нэмэгдсэн байна.

ХҮСНЭГТ 5. МАЛЧДЫН АХУЙ СОЁЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Төрөл	Өрхийн тоо				2019/ 2018	Малчин өрхийн дүнд				Өсөлт бууралт пунктээр
	2016	2017	2018	2019		2016	2017	2018	2019	
Цахилгааны эх үүсгүүр	6128	6211	6167	6314	102.4	88.8	86.5	86.8	87.0	0.2
Нарны	6079	6163	6048	6145	101.6	88.1	85.8	85.1	84.7	-0.4
Салхины	6	11	9	7	77.8	0.1	0.2	0.1	0.1	0.0
Бага оврын цахилгаан	16	9	17	8	47.1	0.2	0.1	0.2	0.1	-0.1
Төвлөрсөн систем	36	49	109	201	184.4	0.5	0.7	1.5	2.8	1.2
Бусад	-	-	-	6	-	-	-	-	0.1	-
Сансрын антен	4989	5051	5164	5454	105.6	72.3	70.3	72.7	75.2	2.5
Телевизор	4995	5359	5535	5696	102.9	72.4	74.6	77.9	78.5	0.6
Радио	2620	2785	2809	3071	109.3	38.0	38.8	39.5	42.3	2.8
Оёдлын машин	3929	3487	3717	4059	109.2	56.9	48.5	52.3	55.9	3.6
Хөлдөөгч	-	1120	1549	1984	128.1	-	15.6	21.8	27.3	5.5
Угаалгын машин	-	953	1106	1415	127.9	-	13.3	15.6	19.5	3.9
Компьютер (Зөөврийн, суурин)	-	46	56	45	80.4	-	0.6	0.8	0.6	-0.2
Гар аргаар хийсэн эсгий, м	19	42	44	31	70.5	0.3	0.6	0.6	0.4	-0.2

ЗУРАГ.4 МАЛЧДЫН НИЙГЭМ, АХУЙН НӨХЦЛИЙГ ХАРУУЛАХ ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ



II.2. Малын тоо, түүний бүтэц, бүрэлдэхүүн

II.2.1 Малын тоо

Нийт мал сүргийн тоо 1970-2018 онд жилд дунджаар 2 хувиар өссөөр, 2018 оны жилийн эцэст малын тоо 3513.4 мянган толгойд хүрсэн байна. Нийт малын тоо өмнөх оноос 7.6 хувь буюу 288.3 мянган толгойгоор буурсан. Мал сүргийн тоо таван төрөл дотор адуу 5.1 хувь, тэмээ 4.1 хувь, өссөн бол ямаа 6.8 хувь, хонь 11.5 хувь, үхэр 0.2 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 6. МАЛЫН ТОО /мян.тол /

Төрөл		2016	2017	2018	2019	2019/2018	
						хувь	зөрүү
Толгой	Бүгд	3497.5	3801.7	3513.4	3597.7	102.4	84.3
	Тэмээ	38.5	42.0	43.7	44.4	101.6	0.7
	Адуу	106.8	123.7	130.0	132.4	101.8	2.4
	Үхэр	71.1	85.4	85.2	84.5	99.2	-0.7
	Хонь	1107.1	1194.6	1057.7	1066.7	100.9	9.0
	Ямаа	2173.9	2356.0	2196.8	2269.6	103.3	72.8
Бодод шилжүүлсэн	Бүгд	692.0	765.6	731.6	745.1	101.8	13.5
	Тэмээ	57.8	62.9	65.5	66.7	101.8	1.2
	Адуу	106.8	123.7	130.0	132.4	101.8	2.4
	Үхэр	71.1	85.4	85.2	84.5	99.2	-0.7
	Хонь	184.5	199.1	176.3	177.8	100.9	1.5
	Ямаа	271.7	294.5	274.6	283.7	103.3	9.1

ЗУРАГ 5. МАЛЫН ТОО, мян.тол /1940-2018 он/




Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл ихээхэн нөлөөлж байсан байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсаны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2009, 2010, 2016, 2018 оны өвөл, хаврын зуд, зундаа гантай байдаг малын тоог ихээхэн бууруулсан байна.

Энэ хандлага тэмээнээс бусад 4 төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй хонь, ямаа хурдан өссөн байна. Харин тэмээн сүргийн хувьд 1990 оноос хойш буурч, 1995-2008 он хүртэл тогтвортой байсан бол 2009 оноос бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж байна. Сүүлийн жилүүдэд ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлага байна.

ХҮСНЭГТ 7. МАЛЫН ТОО, сумаар, толгойгоор, 2016-2019 он


Сум	Малын тоо бүгд /Number of livestock			
	2016	2017	2018	2019
Бүгд	3497492	3801651	3513365	3 597 698
Есөнбулаг	209610	223744	217 869	232 589
Алтай	106433	134765	147 936	151 367
Баян-Уул	245497	232089	188 750	192 676
Бигэр	173436	194444	174 568	184 002
Бугат	150948	178720	190 114	181 103
Дарив	194413	172056	117 679	119 860
Дэлгэр	261217	287930	284 175	305 817
Жаргалан	165991	191599	185 154	193 835
Тайшир	118192	132154	133 345	132 607
Тонхил	240137	269886	232 660	210 048
Төгрөг	156849	174258	125 940	121 261
Халиун	240824	247833	230 804	247 231
Хөхморьт	153372	160598	156 457	166 910
Цогт	277604	307558	287 364	300 962
Цээл	192292	213628	213 656	217 993
Чандмань	199180	228507	223 157	229 726
Шарга	161683	171439	151 941	165 288
Эрдэнэ	249814	280443	251 796	244 423

ЗУРАГ 7. АЙМГИЙН НИЙТ МАЛД СУМДЫН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ /2019 он/



ЗУРАГ 8. МАЛЫН ТОО, сумаар, 2019 он

МАЛЫН ТОО, БҮГД



2019 оны жилийн эцэст тоологдсон малын тоогоор эхний байруудад Дэлгэр сум 305.6, Цогт сум 300.9, Халиун сум 247.1, Эрдэнэ сум 244.4, Чандмань сум 229.7 мянган толгой малтай тэргүүлж байна.

II.2.2 Нийт сүргийн бүтэц

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувийн жинг 2018 оны байдлаар авч үзвэл, ямаа 62.5 хувь, хонь 30.1 хувь, үхэр 2.4 хувь, адуу 3.7 хувь, тэмээ 1.2 хувийг эзэлж байна. 1970 оноос хойш 48 жилийн хугацаанд тэмээний тоо толгой 15.3 хувиар буурсан байхад ямааны тоо толгой 5.3 дахин нэмэгджээ. Сүүлийн 48 жилийн хугацаанд мал сүргийн бүтэц хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзэхэд, ямааны эзлэх хувь 31.4 пунктээр өсөж, харин хониных 23.8 пункт, үхрийнх 2.6 пункт, тэмээнийх 2.6 пункт, адууных 2.5 пунктээр буурчээ.


Малын тоо толгой сүүлийн жилүүдэд нэмэгдсэнээс гадна таван төрлийн малын харьцаа, сүргийн бүтцэд томоохон өөрчлөлт гарсан байна. 1970оны улсын мал тооллогын үр дүнгээс үзэхэд сүрэгт бод мал дунджаар 15 хувь, бог мал дунджаар 85 хувийг эзэлдэг байсан бол 2018 оны байдлаар бод мал дунджаар 7.3 хувь, бог мал дунджаар 92.6 хувийг эзлэх болж, бод малын хувийн жин 7.7 пунктээр буурч, бог малынх 7.6 пунктээр нэмэгджээ.

Манай улсын хонь, ямааны харьцаа 1990 он хүртэл 75:25 буюу 3 хонинд нэг ямаа ногдож байсан. Бог малд хонь 75.0 орчим хувь, ямааны тоо 25.0 орчим хувь байхад сүргийн бүтцэд болон малын бэлчээр ашиглалтад зохистой байсан уламжлалт харьцаа алдагдсаар 25 орчим жил болж байна.

ХҮСНЭГТ 9. НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, төрлөөр

Төрөл	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Тэмээ	1.9	1.6	1.5	0.9	1.3	1.9	1.1	1.1	1.2	1.23
Адуу	2.9	2.9	2.9	2.9	3	3	3.1	3.3	3.7	3.68
Үхэр	1.4	1.4	1.6	1.8	1.9	2	2	2.2	2.4	2.35
Хонь	30.1	28.6	30.2	30.5	30.9	31.1	31.6	31.4	30.1	29.6
Ямаа	63.7	65.6	63.8	63.4	62.9	62.6	62.2	62	62.5	63.1

ЗУРАГ 9. МАЛ СҮРГИЙН БҮТЭЦ, таван төрлөөр эзлэх хувь /2019 он/



II.2.3 Иргэдийн хувийн малын тоо

2019 онд аймгийн хэмжээгээр аминдаа малтай 10521 өрхийн малын тоо энэ онд 3590.3 мянган хүрсэн нь нийт малын 99.7 хувийг эзэлж байна. Энэ нь өмнөх оноос 2.4 хувь буюу 85.0 мянган толгой малаар өссөн байна.

ХҮСНЭГТ 12. МАЛТАЙ ӨРХИЙН АМ БҮЛИЙН ТОО, ТЭДГЭЭРИЙН МАЛЫН ТОО, мянган толгойгоор, 2000-2018 он

Он	Өрхийн тоо	Бүгд	Үүнээс				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2000	12581	2006.6	31.4	91.2	59.3	831.9	992.7
2001	11736	1696.7	28.0	74.7	39.4	683.3	871.2
2002	10330	1004.3	22.0	34.9	16.4	355.4	575.5
2003	10160	1253.5	23.7	40.3	19.7	398.9	770.9
2004	10106	1532.4	24.3	47.0	24.6	479.9	956.6
2005	10159	1825.9	24.8	54.2	30.4	584.6	1131.8
2006	10411	2190.8	25.9	62.5	37.4	700.1	1364.9
2007	10448	2478.5	27.3	71.4	42.3	772.4	1565.2
2008	10606	2497.3	26.9	73.6	41.8	766.1	1588.8
2009	10200	2165.6	26.8	65.8	36.2	691.9	1344.8
2010	9505	1313.6	24.3	38.7	18.3	395.2	837.0
2011	9246	1609.8	25.2	46.5	21.9	460.6	1055.6
2012	9264	1907.1	28.1	55.0	29.3	576.9	1217.8
2013	9395	2219.2	30.4	65.2	39.3	677.8	1406.5
2014	9428	2572.4	32.7	76.6	49.3	796.2	1617.6
2015	9602	2915.8	34.7	88.2	58.6	907.0	1827.3
2016	9932	3491.6	38.5	106.7	70.8	1105.1	2170.5
2017	10180	3793.2	41.9	123.5	84.8	1191.6	2351.6
2018	10315	3505.4	43.6	129.8	84.6	1054.8	2192.6
2019	10521	3597.7	84.5	44.4	132.4	1066.7	2269.6


ХҮСНЭГТ 13. ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН БҮЛЭГЛЭЛТ, 2015-2019 он

Бүлэг	Малтай өрхийн тоо					Малын тоо				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Дүн	9602	9932	10180	10315	10521	2915840	3491568	3793284	3505378	3590328
10 хүртэлх	144	121	118	142	161	906	742	763	964	1039
11-30 хүртэлх	498	424	390	499	497	10710	9 241	8455	10635	10720
31-50	562	521	492	552	540	23020	21 502	20560	23051	22477
51-100	1268	1081	1055	1163	1182	95116	81 090	78974	87734	88323
101-200	2114	2027	1947	2075	2064	314469	301 454	290121	309617	306961
201-500	3262	3415	3584	3547	3653	1047884	1103929	1174038	1157494	1192781
501-999	1334	1697	1848	1782	1870	894785	1148091	1265769	1211018	1269242
1000-1499	357	540	626	473	472	407818	625733	726197	547022	541688
1500-2000	49	78	90	59	60	82559	130512	151058	99177	101270
2001-с дээш	14	28	30	23	22	38573	69274	77349	58666	55827


2019 онд малтай нийт өрхийн 11.2 хувь нь 100 хүртэл малтай, 19.6 хувь нь 100-200 хүртэл малтай, 34.7 хувь нь 201-500 хүртэл малтай, 17.8 хувь нь 501-999 хүртэл малтай өрх эзэлж байгаа бол үлдсэн 5.3 хувийг нь 1000- аас дээш малтай өрх эзэлж байна. 1500-2000 хүртэл малтай өрх 59, 2000 дээш малтай өрх 23 байна.

100-аас дээш малтай өрхийн тоо 2019 онд 8141 болж урьд оноос 2.3 хувиар буюу 182 өрхөөр, 100 хүртэл малтай өрх 1.0 хувиар буюу 24 өрхөөр тус тус өссөн байна.


ЗУРАГ 10. 200 ХҮРТЭЛХ МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, сумаар, 2019 онд




ЗУРАГ 11. 1000-ААС ДЭЭШ МАЛТАЙ ӨРХИЙН ТОО, сумаар, 2019 онд




ЗУРАГ 12. МАЛЫН ТОО, сумаар, мянган толгой, 2019 онд




ЗУРАГ 13. АДУУНЫ ТОО, сумаар, мянган толгой, 2019 онд




ЗУРАГ 13. ТЭМЭЭНИЙ ТОО, сумаар, мянган толгой, 2019 онд




ЗУРАГ 13. ҮХЭР ТОО, сумаар, мянган толгой, 2019 онд



ЗУРАГ 13. ХОНИНЫ ТОО, сумаар, мянган толгой, 2019 онд



ЗУРАГ 13. ЯМААНЫ ТОО, сумаар, мянган толгой, 2019 онд



II.2.4 Хээлтэгч мал

Аймгийн дүнгээр 2019 оны эцэст 1570.8 мянган хээлтэгч тоологдсон нь урьд оныхоос 56.6 мянган толгойгоор өссөн байна. Өмнөх оноос эм ямаа 5.4 хувь, үнээ 24.5 хувь, гүү 11.7, ингэ 5.1 хувиар тус тус өссөн бол эм хонь 0.1 хувиар буурсан байна.


ХҮСНЭГТ 14. ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018 хувь	зөрүү
Бүгд	665841	784771	915793	1046907	1184112	1412013	1514281	1570848	1524826	97.07	46022
Ингэ	8071	8971	9870	10415	11442	12724	13997	14706	15187	103.3	481
Гүү	13942	15573	18753	22013	25757	31622	37079	41399	44741	108.1	3342
Үнээ	10062	12044	15566	18776	22332	26720	26720	33263	34476	103.6	1213
Эм хонь	199181	246036	288450	335694	382432	461391	494389	493755	462997	93.77	30758
Эм ямаа	434585	502147	583155	660009	742149	879556	937480	987725	967468	97.95	20257


II.2.5 Төл бойжилт

2019 оны эхэнд тоологдсон хээлтэгчийн 74.9 хувь буюу 1177.7 мянган эх мал төллөж, гарсан төлийн 94.9 хувь буюу 1121.6 мянган төл бойжжээ. Бойжуулсан төлийн тоо өмнөх оноос 202.6 мянгаар буюу 22.0 хувиар өссөн байна. Гарсан ботгоны 96.1 хувь, унаганы 93.7 хувь, тугалны 94.0 хувь, хурганы 95.3 хувь, ишигний 94.8 хувийг тус тус бойжуулжээ. Төллөвөл зохих 100 хээлтэгч мал тутмаас 74 төлийг бойжуулсан нь өмнөх онтой харьцуулахад 20.5 хувиар өссөн байна.

Хээлтэгч малын эзлэх хувь 2019 онд




Хээлтэгч малын тоо



ХҮСНЭГТ 15. ТӨЛ БОЙЖИЛТ

	2015	2016	2017	2018	2019	Үүнээс:				
						Унага	Тугал	Ботго	Хурга	Ишиг
Гарсан төл	983540	1114290	1336222	952672	1181551	28615	23841	7378	400948	720769
Бойжсон төл	945639	1080628	1306992	919019	1121589	26806	22405	7092	382077	683209
Бойжилтын хувь	96.1	97.0	97.8	96.5	94.9	93.7	94.0	96.1	95.3	94.8

ЗУРАГ 12. Бойжилтын хувь, БОЙЖУУЛСАН ТӨЛ, мянган толгойгоор




II.2.6 Том малын зүй бус хорогдол 18.9

2019 оны эхний малын 57.7 мянган толгой мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оноос 38.8 мянган толгойгоор илүү мал хорогдсон байна. Нийт хорогдолтын 61.3 хувийг ямаа, 30.4 хувийг хонь, 3.7 хувийг адуу, 4.4 хувийг үхэр, 0.2 хувийг тэмээ эзэлж байна.

ХҮСНЭГТ 16. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДОЛ

	2015	2016	2017	2018	2019	2019/2019	
						Хувь	Зөрүү
Дүн	16223	35131	10900	151210	57652	38.1	-93558
Тэмээ	246	187	87	383	134	35.0	-249
Адуу	516	641	311	1977	2146	108.5	169
Үхэр	488	915	286	3367	2506	74.4	-861
Хонь	4764	8280	3279	36999	15502	41.9	-21497
Ямаа	10209	25108	6937	108484	35364	32.6	-73120

ЗУРАГ 13. ТОМ МАЛЫН ЗҮЙ БУСЫН ХОРОГДОЛ, мянган толгойгоор



II.2.7 Малын хээл хаялт, сувайралт

Оны эхний хээлтэгч малын 34.7 хувь буюу 494.2 мянган эх мал хээл хаяж, сувайрсан байна. 2017 онтой харьцуулахад хээл хаясан малын тоо 32 мянган толгойгоор, сувайрсан малын тоо 388 мянган толгойгоор өссөн байна. Нийт хээл хаясан малын 89.9 хувийг, сувайрсан малын 62 хувийг эм ямаа эзэлж байна.


ХҮСНЭГТ 17. ХЭЭЛ ХАЯСАН БОЛОН СУВАЙРСАН ЭХ МАЛЫН ТОО

	Сувайрсан				Хээл хаясан			
	2017	2018	2019	2019/2018	2017	2018	2019	2019/2018
Бүгд	92239	480177	309153	64.4	14061	####	79036	171.8
Ингэ	231	343	324	94.5	24	125	14	11.2
Гүү	4582	10664	11102	104.1	516	839	1364	162.6
Үнээ	3378	7760	8360	107.7	316	561	631	112.5
Эм хонь	28878	163904	88562	54.0	2225	5874	7783	132.5
Эм ямаа	55170	297506	200805	67.5	10980	####	69244	179.3

ХҮСНЭГТ 18. ОНЫ ЭХНИЙ НИЙТ ХЭЭЛТЭГЧИД ХЭЭЛ ХАЯЖ, СУВАЙРСАН ЭХ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

	Сувайрсан					Хээл хаясан				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Бүгд	6.9	6.0	6.5	31.7	20.3	2.0	2.7	1.0	3.0	5.2
Ингэ	3.8	2.1	14.5	28.8	2.1	0.1	0.4	1.6	2.3	0.1
Гүү	14.6	13.2	12.6	24.8	24.8	2.5	2.5	1.2	1.8	3.0
Үнээ	14.3	12.0	1.8	2.5	24.2	1.3	2.1	0.2	0.9	1.8
Эм хонь	5.9	5.8	6.3	33.2	19.1	0.8	1.1	0.5	1.2	1.7
Эм ямаа	7.0	5.7	6.3	31.7	20.8	2.7	3.6	1.2	4.1	7.2

ЗУРАГ 14. МАЛЫН ХЭЭЛ ХАЯЛТ, СУВАЙРАЛТ, мянган толгойгоор



II.2.8 Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо

2019 онд 23.3 мянган хээлтүүлэгч малын тоологдож өмнөх оноос 293 толгойгоор өссөн байна.

ХҮСНЭГТ 19. ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Бүгд	9045	12607	14939	16949	19120	21468	23315	23407	23027	23320
Буур	297	338	360	365	410	448	469	468	482	500
Азарга	2128	2379	2574	2923	3325	3804	4413	4942	5449	5768
Бух	326	491	597	832	1057	1243	1401	1539	1453	1515
Хуц	2583	3838	4555	5068	5657	6451	6793	6495	6282	6132
Ухна	3711	5561	6853	7761	8680	9522	10239	9963	9361	9405

2019 оны нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тооноос харахад хээлтэгч, хээлтүүлэгчийн тохиргоо нь бод малын хувьд (үнээ, ингэнээс бусад) үржлийн нормоор харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна.

Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ноогдох ёстой атал 2019 онд аймгийн дунджаар 74 эм хонь, 103 эм ямаа ноогдож 6 дахин өндөр үзүүлэлт гарч байна.

ХҮСНЭГТ 20. НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НОГДОХ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

	Үржлийн норм	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Ингэ	20-25	27	27	27	29	28	28	30	31	32
Гүү	12-15	7	7	7	8	8	8	8	8	8
Үнээ	35-45	31	25	26	23	21	21	19	22	24
Эм хонь	25-30	77	64	63	66	68	72	73	76	74
Эм ямаа	25-30	117	90	85	85	86	92	92	99	103

II.2.9

Малын хэрэглээний зарлага

ХҮСНЭГТ 21. МАЛЫН НИЙТ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

	2015	2016	2017	2018	2019	2019/2018 хувь
Бүгд	476539	470576	991933	1056095	870970	82.5
Тэмээ	2921	1923	9489	17013	6792	39.9
Адуу	7786	2869	8847	18911	22816	120.6
Үхэр	7339	6364	2983	4705	21995	467.5
Хонь	169749	155505	345638	411615	317884	77.2
Ямаа	288744	303915	624976	603851	501483	83.0

ХХҮСНЭГТ 22. ОНЫ ЭХНИЙ МАЛД ЭЗЛЭХ ХУВЬ

	2015	2016	2017	2018	2019	2019/2018 хувь
Бүгд	16.3	16.1	28.4	27.8	24.2	87.1
Тэмээ	8.4	5.5	8.9	13.8	15.3	110.8
Адуу	8.8	3.2	12.5	22.1	17.2	78.0
Үхэр	12.5	10.8	7.7	11.2	26.0	232.5
Хонь	18.7	17.1	31.2	34.5	29.8	86.4
Ямаа	15.8	16.6	28.7	25.6	22.1	86.3

Оны эхний малын 24.2 хувь буюу 870.1 мянган толгой малыг хэрэглээнд зарцуулсан нь 2018 оноос 185.1 мянган толгойгоор буюу 17.5 хувиар хэрэглээнд зарцуулт буурсан байна. Хэрэглээнд зарцуулсан малын 5.9 хувийг бод мал эзэлж, 94.1 хувийг бог мал эзэлж байгаагаас оны эхний нийт малаас тэмээний 15.3 хувь, адууны 17.2 хувь, үхрийн 26.0 хувь, хонины 29.8 хувь, ямааны 22.1 хувийг хэрэглээндээ зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 23. ХЭРЭГЛЭЭНИЙ МАЛЫН ТОО ТӨРЛӨӨР

	Зах зээлд худалдан борлуулсан					Хүнсэнд хэрэглэсэн				
	2015	2016	2017	2018	2019	2015	2016	2017	2018	2019
Бүгд	207538	206282	636215	631992	662854	180914	180171	226893	205222	208116
Тэмээ	1256	999	10431	13291	5931	775	673	2685	2900	861
Адуу	3167	3240	8932	14995	19319	2090	1983	3329	3879	3497
Үхэр	3129	4060	2792	3883	17968	2409	2671	716	774	4027
Хонь	72554	73718	218048	244413	227061	71404	71596	91975	87821	90823
Ямаа	127432	206282	396012	355410	392575	104236	103248	128188	109848	108908

II.10 Тэжээвэр амьтад

2018 онд 452 гахай, 41 шувуу тоологдсон нь 2017 оныхоос гахай 16, шувуу 41, илжиг 2-оор тус тус буурсан байна. 2019 онд 89 гахай, 70 шувуу, илжиг 36 тус тус тоологдсон байна.

ХҮСНЭГТ 24. ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2019/2018	
									хувь	зөрүү
Гахай	57	129	231	358	491	468	452	89	19.69	-363
Шувуу	1528	149	146	158	85	82	41	70	170.7	29
Илжиг	59	37	25	16	33	36	34	36	105.9	2

II.11 Малжуулалтын талаарх мэдээлэл

Монгол улсын Засгийн газрын ядуурлыг бууруулах ажлын хүрээнд малгүй болон мал цөөтэй иргэдийг малжуулах арга хэмжээг авч, нилээдгүй хөрөнгө мөнгийг зарцуулсан байна. Малжуулах арга хэмжээ нь орон нутгийн хөрөнгөөр 255.6 сая төгрөг, гадаад улс орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр 57.4 сая төгрөг, бусад хөрөнгө оруулалтаар 199.6 мянган төгрөгийн санхүүжилтээр хийгджээ.

ХҮСНЭГТ 25. МАЛЖУУЛАЛТАНД ХАМРАГДСАН ӨРХИЙН ТОО, АМ БҮЛИЙН ТОО, МАЛЖУУЛАЛТААС АВСАН МАЛЫН ТОО, МАЛЖУУЛАЛТААР ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГӨ /сая төгрөг/

		2016	2017	2018	2019	2019/2018 Хувь
Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо		379	202	289	148	51.2
Ам бүлийн тоо		1547	791	1180	667	56.5
Нэг өрхөд ногдох ам бүлийн тоо		5	4	4	5	125.0
Малжуулалтаас авсан малын тоо		15287	13075	12114	7536	62.2
Үүнээс:	Бод малын тоо	338	82	543	148	27.3
	Бог малын тоо	14949	12993	11571	7388	63.8
Нэг өрхөд ногдох малын тоо		40	65	42	50	119.0
Малжуулалтаар зарцуулсан хөрөнгө мян.төг		958.1	524.1	846.4	512.6	60.6
Үүнээс:	Гадаад орон, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хөрөнгөөр	81.2	49	101.4	57.4	56.6
	Орон нутгийн хөрөнгөөр	591.5	239	297.4	255.7	86.0
	Бусад	285.7	236.1	447.3	199.6	44.6

2019 онд 148 өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан бөгөөд нэг өрхийн ам бүлийн тоо дунджаар 5 хүн байна. Малжуулалтанд хамрагдсан өрхийн тоо өмнөх оноос 141 өрхөөр буурчээ. Малжуулах арга хэмжээгээр дээрх өрхүүдэд нийт 7536 толгой мал олгогдсон бөгөөд 98.0 хувь нь бог мал байна. Малжуулалтанд нийт 512.6 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна.

II.12 Худаг усан сангийн тоо, усжуулалтын талаарх мэдээлэл

2019 онд 42 худаг шинээр гаргахад төсвийн хөрөнгөөр 354.9 сая төгрөг зарцуулсан байна. Шинээр гаргасан худгийн тоо өмнөх оныхоос 18-аар өсчээ. 42 худаг сэргээн засварласны 32 нь энгийн уурхайн, 10 нь инженерийн хийцтэй худаг байсан бөгөөд худгийн засвар шинэчлэлтэд нийт 105.5 сая төгрөг зарцуулжээ.

ХҮСНЭГТ 26. ШИНЭЭР ГАРГАСАН ХУДГИЙН ТАЙЛАН

		2015	2016	2017	2018	2019	2019/2018 хувь
Шинээр гаргасан худгийн тоо		30	13	22	24	42	175.0
Үүнээс:	Инженерийн хийцтэй өрөмдмөл	22	7	14	13	38	292.3
	Энгийн уурхайн	8	6	8	11	4	36.4
Шинээр гаргахад зарцуулсан хөрөнгө сая.төг		8994	188.9	199.3	348.7	354.9	101.8

ХҮСНЭГТ 27. ЗАСВАРЛАСАН ХУДГИЙН ТАЙЛАН

		2015	2016	2017	2018	2019	2019/2018 хувь
Засварласан худгийн тоо		63	79	22	23	42	182.6
Үүнээс:	Инженерийн хийцтэй өрөмдмөл	10	7	-	7	10	142.9
	Энгийн уурхайн	53	72	22	16	32	200.0
Засварлахад зарцуулсан хөрөнгө, сая.төг		5208	116.3	20.3	40.5	105.5	260.5

ГУРАВ. МАЛ СҮРГИЙН БЭЛЧЭЭРИЙН ДААЦ, ТЭЖЭЭЛИЙН НӨӨЦ

III.1 Малын бэлчээрийн даац

Газрын албаны 2019 оны газрын нэгдмэл сангийн тайлангаар манай аймгийн бэлчээр хадлангийн талбай 7976.2 мянган га талбай болж, өмнөх оныхоос 360.7 мянган га-гаар буурсан байна. Аймгийн хэмжээнд 360.7 мянган га талбай бүхий газрыг говийн их дархан цаазат газрын “Б” хэсэгт нэмэж хамгаалтанд авсантай холбоотой бэлчээрийн талбайн хэмжээ буурсан байна.

ХҮСНЭГТ 28. Бэлчээрийн хүрэлцээ хангамж

	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019
Хадлан бэлчээрийн талбай, мян.га	8536	8536.1	8336.8	8337	8337.2	8337	8336.9	7976.2
100 га хадлан, бэлчээрийн талбайд ноогдох хонин толгойд шилжүүлсэн малын тоо	28	33	39	44	53	57	56	60

“МАЛ СҮРГИЙН ТООГ БЭЛЧЭЭРИЙН ДААЦ, НӨХЦӨЛТЭЙ УЯЛДУУЛЖ ТОГТООХ” судалгаагаар 2018 онд бэлчээрийн хэмжээнд тохируулан тооцсон малын тоо 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 56 байна. 2019 онд 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр 60 толгой мал ноогдож, дээрх үзүүлэлтээс 4 толгой малаар хэтэрсэн байна.

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөхийн хэрээр 100 га хадлан бэлчээрийн талбайд ноогдох малын тоо зарим сумуудад их хэмжээгээр нэмэгдэх хандлагатай байна. 100 га хадлан, бэлчээрийн талбайд хонин толгойд шилжүүлснээр аймгийн дундаж 60, Есөнбулаг 148, Халиун 121, Жаргалан 81 толгой мал ноогдож байгаа аймгийн дундаас 1.4-2.4 дахин их байна. Хамгийн бага мал ноогдож байгаа сум Алтай, Баян-Уул сумдад 22-52 мал ноогдож байна. Хавсралт, хүснэгт 17.2–оос үзнэ үү.

III.1 Тэжээлийн хүрэлцээ, хангамж

2018 онд аймгийн хэмжээгээр 7481.3 тн хадлан, 730.3 тн тэжээлийн ургамал, 140.7 тн гар тэжээл, хужир шүү 4535.6 тус тус бэлтгэсэн байсан бол 2019 онд 1258.2 тн буюу 16.8 хувиар хадлан, 96.4 тн буюу 12.8 хувиар гар тэжээл нэмэгдсэн бол, 80 тн буюу 4.2 хувиар тэжээлийн ургамал, хужир шүү 623 тн буюу 13.7 хувиар тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 29. БЭЛТГЭСЭН ТЭЖЭЭЛ, нэр төрлөөр /тн/

	2015	2016	2017	2018	2019	2019/2018
Хадлан	5912.8	5169.3	7568.2	7481.3	8739.5	116.8
Тэжээлийн ургамал	1159.3	1545.9	262.8	1919.3	1839.3	95.8
Гар тэжээл	190.9	283.2	533.3	750.3	846.7	112.8
Хужир	1848.8	2879.5	3727.4	4535.6	3912.6	86.3

Дүгнэлт

Манай Улсын эдийн засаг, нийгмийн амьдралд хөдөө аж ахуйн салбар шийдвэрлэх ач холбогдолтой асуудлууд хэвээр байгаа билээ. Нийт мал сүргийн тоо 1970 оноос 2019 оны хооронд жилд дунджаар 2 хувиар өссөөр, 2019 оны жилийн эцэст малын тоо 3597.7 мянган толгойд хүрсэн байна. Нийт малын тоо өмнөх оноос 2.4 хувь буюу 84.3 мянган толгойгоор өссөн байна. Мал сүргийн тоо таван төрөл дотор адуу 1.9 хувь, тэмээ 1.8 хувь, өссөн бол ямаа 3.3 хувь, хонь 0.9 хувиар тус тус өссөн бол үхэр 0.9 хувиар буурсан байна. Малын тоо буурахад цаг агаарын хүндрэл, малчид малаа эдийн засгийн эргэлтэд ихээхэн оруулсан нь харагдаж байна. Сүүлийн жилүүдэд ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлага байна. 2019 оны эхэнд тоологдсон хээлтэгчийн 77.2 хувь буюу 1177.7 мянган эх мал төллөж, гарсан төлийн 94.6 хувь буюу 1121.6 мянган төл бойжжээ. Бойжуулсан төлийн тоо өмнөх оноос 170.9 мянгаар буюу 17.9 хувиар өссөн байна.

Аймгийн хэмжээнд 2019 оны жилийн эцэст 16075 өрх байгаагаас малтай 10521 өрх тоологдсны 7255 өрх буюу 68.9 хувь нь малчин өрх, 3266 өрх буюу 31.1 хувь нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй мал бүхий өрх байна.

